



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/730

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн үйлчилгээг ард иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, бүртгэлийн ажлыг чанаржуулах, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үйлсэд хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Цэгмэдийн Энх-Амгалан, Дэвээгийн Чулуунцэцэг нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Ц.Энх-Амгалан, Д.Чулуунцэцэг нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /С.Хоролсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ